



**"СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ" ТӨСЛИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР
/БАЯНХОНГОР, ЖАРГАЛАНТ СУМ/**

2024 оны 10 дүгээр сарын 03 ны өдөр

№ 03

Номгон

1	Үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 3.6.1; - Баянхонгор аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр;
2	Зорилго	Жаргалант сумын төвийн инженерийн шугам сүлжээг сайжруулах, инженерийн дэд бүтцэд холбоно. Тус сумын иргэд эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хангагдаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ариутгах татуургын шугамд холбогдохын зэрэгцээ төвлөрсөн дулаан хангамжтай, тав тухтай орчинд ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.
3	Байршил	Баянхонгор аймаг, Жаргалант сумын төв Эмээлтолгой багийн нутаг дэвсгэрт <i>/Төлөвлөлтийн хязгаар, хамрах хүрээг хавсралт 1/</i>
4	Иинженерийн шугам сүлжээний одоогийн байдал	<p>Газарзүйн байрлал Жаргалант сум нь Хангайн нурууны өвөрт, Улаанбаатар хотоос 830 км, аймгийн төвөөс 180 км зайд оршдог. Хүн ам: Жаргалант сум нь 2835 хүн амтай. /2023 оны байдлаар/ Жаргалант сумын инженерийн хангамжийн одоогийн байдал: Цахилгаан хангамж: Баянхонгор аймгий төвийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон. 15 кВ-ын ЦДАШ, Заг дэд станц Заг 35/10 кВ 1000 кВА-д 2014 онд ашиглалтад оруулсан. Одоогоор ашиглалтгүй 400 квт-ын эрчим хүч гаргах чадалтай хуучин цахилгаан станц бий. Ус хангамж: Сумын төвд унд ахуйн худгаас зөврөөр 3, эх үүсвэрийн гүний худаг-4, ахуйн гүний худаг-0 хангадаг. /"Баянхонгор эко дулаан" ХХК-ын халаалтын зуухны хашаанд гүний худаг 1.3 л/сек/. 2021 онд сумын төвийн төрийн өмчийн барилга байгууламжууд дулаан хангамжийн системд холбогдсон бөгөөд дулааны шугамын сувагчлалд цэвэр усны түгээх шугам хамт тавигдсан. Сумын төвийн ус хангамжийн хэрэгцээг хангах усны эх үүсвэрийн хайгуул, шинжилгээ хийх шаардлагатай. Дулаан хангамж: Сумын төвийн дулааны хангамжийг "Баянхонгор эко дулаан" ХХК хариуцан хангадаг. Одоо байгаа халаалтын зуух Экономайзер 1.25 маркийн 1.5 МВт хүчин чадалтай 2 тогоо суурилагдсан. Төсвийн 6 байгууллага, 5 аж ахуйн нэгж, 76 айл өрхийг дулаанаар хангаж байна. Хуучин ашиглаж байсан 8 тогоотой уурын зуух бий. Ариутгах татуургын шугам: Сумын төвд одоогоор нэгдсэн ариутгах татуургын систем болон цэвэрлэх байгууламж байхгүй ба бохирын 4 цооногтой. Хуучин ашиглаж байсан цэвэрлэх байгууламж бий. Холбоо мэдээллийн сүлжээ: Мобиком, Жи-Мобайл, Юнител үүрэн холбооны сүлжээнд холбогдсон. Радио, телевизийн 6 суваг, радио, телевиз тоон системд шилжиж шилэн кабелийн шугам тавигдсан.</p>
5	Хэрэглэгчийн ачаалал	<p>Одоо байгаа барилга, байгууламжууд:</p> <ul style="list-style-type: none"> • ЗДТГ, засаг захиргаа • Соёлын төв • Сургууль, сургуулийн дотуур байр • Цэцэрлэгийн барилга • Эрүүл мэндийн төв, эмнэлэг, амбулатори

		<ul style="list-style-type: none"> • Халдвартын эмнэлэг • Цагдаагийн барилга • Цагдаагийн тасгийн барилга • Онцгой байдлын авран хамгаалах албаны байр • Халуун усны барилга • Үйлдвэрийн барилга • Сумын төвийн хэсэгт байрлах ахуйн үйлчилгээ, дэлгүүр, цайны газар зочид буудал, халуун ус • <u>Сумын төвийн эхний ээлжийн боломжит айл өрхүүд</u>
6	Зураг төсөл, бүрдэл, тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Байр зүйн дэвсгэр зураг /М:500/ - Инженер геологийн судалгааны ажлын тайлан /дүгнэлт/ <p><i>/Ажлын даалгаврыг гүйцэтгэгч нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай зөвшилцөнө./</i></p> <ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээний иж бүрэн ажлын зураг /М:100-М:500/: <p>Дулаан хангамж:</p> <ul style="list-style-type: none"> - 2000 у/м – гадна дулааны хос шугам, /дулааны сувагт/ сувгийн трасс төлөвлөх /Хуучин байгаа шугамыг шинэчлэн, өргөтгөх, нэмэгдүүлэх, хэрэглээний халуун усны шугамын хамт төлөвлөх/; <p>Ус хангамж, ариутгах татуурга:</p> <ul style="list-style-type: none"> - 2500 у/м гадна ус хангамжийн шугам /дулааны сувагт/ шинэчлэх / нэмж төлөвлөх/; - 2500 у/м ариутгах татуургын шугам. <p>Цахилгаан хангамж:</p> <ul style="list-style-type: none"> - 800 у/м шугам, 15/0.4кВ-ын дэд станц – цэвэрлэх байгууламж болон усан сангийн гадна цахилгааны шугам <p>Холбоо дохиолол: Камержуулалт Үерийн хамгаалалтын далан, суваг: 800 у/м үерийн хамгаалалтын далан суваг</p> <p><i>/Одоо байгаа барилгуудыг инженерийн шугам сүлжээтэй холбож байгаагаар холбогдуулан нэмэлт ажилбаруудыг хамт төлөвлөх шаардлагатай./</i></p> <ul style="list-style-type: none"> - Инженерийн байгууламж /эх үүсвэрүүд/-ийн ажлын зураг: - 50 м³/хоног–оос багагүй цэвэрлэх байгууламж /Хуучны цэвэрлэх байгууламжийг судлаж, дүгнэлт гаргуулан ашиглах боломжийг судлах/; - 50 м³ /Сүүлийн үеийн стандартын дагуу/ – усан сан, насос станц. - Халаалтын зуух- 1 шинээр төлөвлөх. <p><i>/Нэг маягийн зураг төсөлтэй холбох/</i></p> <ul style="list-style-type: none"> - Тохижилт, ногоон байгууламжийн ажлын зураг: - Явган хүний зам, талбай /3000 м²/; - Мод бут сөөг, зүлэгжүүлэлт хийх /2000 м²/; - Гудамж, замын гэрэлтүүлэг - /80 ш /; - Инженерийн байгууламж, шугам сүлжээ, тохижилт, ногоон байгууламжийн ажлын зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Авто зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох; - Бүх ажлын зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөж, батлуулсан байх; - Ажлын зураг төслийг норм, дүрэм стандартын дагуу төлөвлөх ба тохижилтын элементүүдийн ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;


		<ul style="list-style-type: none"> - Ажлын зураг төсвийг боловсруулахдаа Жаргалант сумын удирдлага, иргэдтэй зөвшилцөх; - Батлагдсан иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв, тайлбар бичгийг хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 4 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, Баянхонгор аймгийн ЗДТГ-т 1, Аймгийн ГХБХБГ-т 1, Жаргалант сумын ЗДТГ-т 1 хүлээлгэн өгнө.
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд хугацааг тодорхой заасан байна. /Гэрээ байгуулснаас хойш ... сарын хугацаанд багтаан гүйцэтгэнэ/
8	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль; - Геодези, зураг зүйн тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Усны тухай хууль; - Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Сэргээгдэх эрчим хүчний тухай; - Эрчим хүч хэмнэлтийн тухай; - Бусад хууль тогтоомж; <p>Норм норматив, стандарт:</p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04); - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм /ЗГ-ын 2019 оны 108 дугаар тушаал/; - Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил /БД 11-105-06/; - 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил /БД 11-106-08/; - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм ба дүрэм /БНБД 21.02.02/ - "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг" /MNS 6736:2018/; - "Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" /БНБД 11-07-19/; - "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД11-105-06 (БХБ-ын Сайдын 2006 оны 116 дугаар тушаал); - "Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезин ажил" БД-11-115-16 (БХБ-ын Сайдын 2016 оны 25 дугаар тушаал); - "Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж" БНБД 40-02-16 (БХБ-ын сайдын 2016 оны 116 дугаар тушаал); - "Дулааны сүлжээ" БНБД 41-02-13 (БХБ-ын сайдын 2014 оны 136 дугаар тушаал); - Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНБД 11-04-16/; - Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт.
9	Баримт бичиг боловсруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
10	Ажил гүйцэтгэх байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага.
11	Захиалагч байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

12	Зөвшөөрөлцөх байгууллага	<p>Ажлын зураг төсөл зөвшилцөх байгууллага:</p> <ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагууд; - Жаргалант сумын ЗДТГ, удирдлагууд; - Баянхонгор аймгийн ЗДТГ, Аймгийн Ерөнхий архитектор, аймгийн ГХБХБГ. <p>Ажлын зураг төслийн хяналт, магадлал хийлгэх:</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналтын дүгнэлт гаргуулах; - Барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын хяналтын дүгнэлт гаргуулах; - Барилгын зураг төсөлд Магадлалын дүгнэлтийн нэгтгэл гаргуулах /"Барилгын хөгжлийн төв"ТӨҮГ/
13	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Инженерийн байгууламж шугам сүлжээний ажлын зураг төслийг эх үүсвэр болон хэрэглэгчтэй холбох хүртэл иж бүрнээр боловсруулах; - Дулааны гол болон салбар шугам шинэчлэн солих ба хэрэглэгч байгууллагуудын дулааны зангилаа /узельд/-д холболт хийх; - Хуучин ашиглаж байсан цэвэрлэх байгууламжийг дахин ашиглах талаар судлаж, дүгнэлт гаргуулах; - Газар хөдлөлтийн нөлөөллийг тооцох; - Инженер геологийн дүгнэлтийг үндэслэн хөрсний усны хэлбэлзлээс үүсэх эрсдэлийг тооцоолон хамгаалах арга хэмжээнүүдийг холбогдох норм, дүрэм, зааврын дагуу төлөвлөх; - Газар доорх болон дээрх инженерийн байгууламжтай огтлолцох, давхцах тохиолдол бүрд шаардлагатай нэмэлт арга хэмжээ авахад гарах зардлыг ажлын зураг, хяналтын төсөвт тусгах; - Шаардлагатай нөхцөл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх.

ХЯНАСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Л.МАНДАЛ

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Д.АЛТАНГЭРЭЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР  С.ХҮРЭЛХУЯГ

БОЛОВСРУУЛСАН:
ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР, ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Ө.ХАНДАРМАА

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТӨВ



Одоо байгаа инженерийн шугам сүлжээ

- Худаг
- Дулааны_худаг
- Дулааны шугам